

ӨНӨӨГИЙН МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ТАЛААРХ ГЕРМАНЫ НЭГЭН МОНГОЛ СУДЛААЧИЙН СЭТГЭГДЭЛ

Удо Б. Баркманн*

Өнөөдөр ойн өдрийг нь тэмдэглэж буй Монгол улсын Гадаад Явдлын яамны сайд асан Мангалын Дүгэрсүрэн (1922-2002) тус орны гадаад бодлогын тулгын чулууг өрөлцсөн анхны чухал архитекторч байсан гэдэгтэй хэн ч тэгтлээ маргахгүй биз ээ. Ямартай ч түүнийг Элчин сайд, Гадаад Явдлын яамны 1-р орлогч сайд, жинхэнэ сайд байсан он жилүүдэд Монгол улс НҮБ-д элсч, БНХАУ-тай хилийн гэрээ байгуулан (1962.12.26), ная орчим улс орон Монгол улсыг дипломатын талаар хүлээн зөвшөөрсний дээр дипломат албыг бүрдүүлэн өргөтгөх ажлууд хийгдсэн билээ. Эдгээр үе шатны аль нь ч Монгол орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэхжүүлэхэд шийдвэрлэх хувь нэмэр оруулсан юм. Монгол улс үндэстний нэн ярвигтай түүхийг бүхэлд нь мэдэх хүн л тухайн үед хийгдсэн эдгээр ажлын цар хүрээ, ач холбогдлыг жинхэнэ ёсоор нь ойлгох ажгуу.

Түүний халааг авч 1988 онд Гадаад Явдлын яамны сайдаар томилогдсон Ц. Гомбосүрэнд ч гэсэн улс төр, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлийн нөхцөлд дээрхтэй төсөөтэй томоохон үүрэг ноогдсон юм.

Уг өөрчлөлт шинэчлэл Монгол улсыг олон улсын эрх зүйн хувьд ямар ч хязгааргүй бүрэн эрхт субъект болгон хувиргаснаар үндэсний хийгээд бусдын эрх ашгийг харилцан ашигтай байх үндсэн дээр тэнцвэржүүлэх явдлыг гадаад бодлогынхоо эрхэм дээд зорилго хэмээн тодорхойлох болов. Одоо бол Монголын гадаад бодлого өөрчлөгдсөн шинэ нөхцөлд Монгол улсын оршин тогтнох орчныг бүрдүүлэх хатуухан сорилттой тулгарсан ч бүр анхнаасаа л АНУ, Япон, Герман зэрэг орны тусламж дэмжлэгт тулгуурлах боломжтой байсан билээ. Япон улс 1991 онд Монголд хандивлагч орнуудын бага хурлыг анх санаачлан хийлгэсэн нь тэр цагаас хойш хөнгөлөлттэй зээл, тусламж

*МУИС-ийн Монгол судлалын төвийн зочин профессор, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн дэргэдэх Герман судлалын төвийн гүйцэтгэх захирал

олгох замаар Монголд явагдаж буй ардчилсан болон эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлд дэмжлэг үзүүлсээр ирлээ. Монгол улс ардчиллыг тууштай баримталж байгаа нь ёс суртахууны таатай нөхцлийг бий болгож байна. Олон улсын Валютын сан, Сэргээн босголт, хөгжлийн олон улсын банк (IBRD), Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын банк-санхүүгийн чухал байгууллагууд Монгол улсыг бүр 1991 онд л гишүүнээрээ элсүүлэн авчээ.

Монгол улсын Гадаад харилцааны яам 1991 оны эцэс гэхэд үндэсний эрх ашгаа хамгаалахыг эрхэм дээд зарчмаа болгосон олон тулгуурт гадаад бодлогын загварыг боловсруулан гаргасан юм. Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн хэвлэлд өгсөн нэгэн ярилцлагатаа 1-рт хоёр хөрштэйгөө, 2-рт Азийн орнуудтай, 3-рт барууны өндөр хөгжилтэй орнуудтай, 4-рт хөгжиж буй орнуудтай, 5-рт олон улсын байгууллагуудтай тогтоосон харилцаагаа хөгжүүлэх явдлыг гадаад бодлогынхоо тулгуур багана хэмээн нэрлэсэн байдаг.¹

Гэвч энэ бодлогоо хэрэгжүүлэхийн тулд эхлээд Орос, Хятад хоёр улстай харилцах харилцаагаа шинээр зохицуулах шаардлагатай болов. Тийм ч учраас 1992 оны тавдугаар сарын 13-ны өдөр батлагдсан “Монгол улсын Аюулгүй байдлыг хангах тухай хууль”-д юуны өмнө улс орны “тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй байдал, хилийн дархан байдал”-ыг үндэсний аюулгүй байдлын тулгуур зүйлс болгон тодорхойлсон юм.

Монголын гадаад бодлогод үзүүлэх дарамт шахалт Оросын Холбооны Улс (1993 оны нэгдүгээр сарын 20) болон Бүгд Найрамдах Хятад Ард Улстай (1994 оны дөрөвдүгээр сарын 29) “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” байгуулсны дараа л буурч эхэлсэн билээ. Орос улс ЗХУ-ын хууль ёсны залгамжлагчийн хувьд хүлээсэн үүргээ биелүүлэхээ илэрхийлсэн боловч хуучин Зөвлөлтийн зүгээс Монголд явуулж байсан хэлмэгдүүлэлтийг “өнөөгийн Орос улсад холбогдолгүй” болгохыг шаарджээ. Хятад улс “бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрх, харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр” Монгол улстай найрсаг харилцаагаа хөгжүүлэхээр шийдсэн байна.

¹ Ц. Гомбосүрэн, Ардын эрх, 1991.12.28

Орос болон Хятад улстай харилцах харилцаагаа тодорхой болгосон явдал Монгол улс 1994 онд үндэсний аюулгүй байдлын тухай ойлголтоо шинээр тодорхойлох боломж олгов. Улс орон оршин тогтнох ерөнхий аюулгүй байдлын зэрэгцээ төр, нийгмийн байгууллагуудын аюулгүй байдал, мөн иргэдийн эрх, эрх чөлөө, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, мэдээлэл, монгол түмний соёл иргэншил, хүн ам, удмын сан, тэрчлэн байгаль орчны аюулгүй байдал ч үүрэг рольтой болж ирлээ. Олон тулгуурт гадаад бодлогын үзэл санаа 1994 онд батлагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д бүрэн тусгагдаж, тэр үеэс эхлэн Монголын гадаад бодлогын тулгуур багана болж байна.

Олон тулгуурт гадаад бодлого хэмээх ухагдахуун тун ч логик авцалдаатай мэт сонсогдож байвч олон улсын харилцаанд тодорхой нэг логикийг баримтлан дагаж мөрдөх нь ховорхон байдаг. “Гадаад бодлогын үзэл баримтлал” батлагдан гарч байх 1994 онд хоёр талын болон олон улсын гол байгууллагуудтай тогтоосон харилцаа нэн чухал үүрэгтэй байсан бол өнөөгийн Монгол улсын гадаад бодлого хоёр талын харилцааны үзэл баримтлалаа бүс нутгийг интеграцчилах эрмэлзэлтэй хэрхэн уялдуулж хөгжүүлэх вэ гэдэг үзэл баримтлалын шинжтэй бодол санаанд анхаарлаа хандуулах шаардлагатай улам бүр тулгарах боллоо.

Үүний нэг тод жишээ гэвэл, бүс нутгийн хязгаарлагдмал хүрээний аюулгүй байдлын түншлэлээс эдийн засгийн интеграцийн чиглэл рүү илүүтэй хөгжиж байгаа мэт санагдах болсон Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага юм. Гэвч интеграцчилах ийм эрмэлзлийн цаана үндэсний хүчтэй эрх ашиг нуугдан байх нь элбэг тохиолддог бөгөөд Шанхайн байгууллагын хувьд энэ нь соёлын талаар өөр хоорондоо эрс ялгаатай Орос, Хятад гүрнүүдийн ашиг сонирхлоор илэрч байна. Надад бол дээрх хоёр орны өнөөгийн хамтын ажиллагаа “ёсыг бодож суусан хосууд” шиг санагддаг. Ийм маягаар хамтрах нь өнөөгийн Орос орны эдийн засгийн доройтолтой ямар нэг байдлаар холбоотой биз. Гэвч ийнхүү “ёсыг бодож суусан гэр бүл” аливаа ачаалал, хүндрэлтэй тулгармагцаа хэврэгхэн болдог.

Эдийн засгийн өсөлт нэг талдаа сул дорой, нөгөө талдаа эрчимтэй байгаа нь тэгш бус байдлыг бий болгож, нэг тал нь нөгөөгөөсөө хараат болоход ч хүргэж болох юм. Яг ийм үед нэг талынх нь иргэд нөгөө талынхаа хууль ёсны нутаг дэвсгэрт үй олноороо нэвтэрч, тухайн бүс нутгийн эдийн засгийн амьдралын зарим хэсэгт зонхилох байр суурь эзлээд, харин олсон ашгаа эх нутаг руугаа зөөгөөд байвал үүнээс өөр хэмжээний маш

олон асуудалтай тулгарах болно. Энэ нь тухайлбал, эрчим хүч, түүхий эдийн нөөцөд хүрэх замд нь саад учруулах гэх мэтээр нэг тал нь нөгөөгийнхөө өсөлтийг сааруулах сонирхолд ч аваачиж мэдэх билээ. Монголын гадаад бодлогын хувьд энэ бол анзааралгүй өнгөрч хараахан боломгүй хүчин зүйл болов уу.

Энхийг сахиулах ажиллагаа (Peace-Keeping), аюулгүй байдлын түншлэл зэрэг нь олон улсын харилцаанд бий болсон шинэхэн боломжууд болох нь лавтай. Монгол улс энэ тал дээр тодорхой хувь нэмэр оруулах чадвартай гэдгийг дэлхийн янз бүрийн өнцөг буланд очиж ажилласан монгол цэргүүд маш амжилттай харууллаа. 2002 оны наймдугаар сарын 8-нд Хойд Солонгостой байгуулсан “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” ч гэсэн Монголын гадаад харилцаа гартаа атгасан хөзрийн чухал тамга мөнөөс мөн. Монгол улс ингэснээрээ Солонгосын хойг дээрх асуудлыг шийдвэрлэхэд оролцох чухал түншүүдийн нэг болж байна.

Монголын гадаад бодлого өнөөдөр асар өндөр шаардлагуудтай тулгараад байгаа билээ. Олон улсын харилцааны томоохон сүлжээг бий болгож чадсан ч түүнийхээ эрч хүчийг алдуулалгүй авч явах нь одоо байгаа боломжийн хирээс хэтрэх нь олонтаа ажиглагдаж байна. Тийм учраас боловсон хүчний залгамж чанарыг хадгалах, стратегийн чухал түнш орнууд дахь Элчин сайдуудынхаа суларсан орон тоон дээр орных нь хүнийг яаралтай томилон суулгах зэрэг нь багагүй ач холбогдолтой юм.

Монголын гадаад бодлого өдгөө тус оронтой шууд хил залгаа оршдог, түүхий эдийн өлсгөлөн, эрчим хүчний хомсдолд нэрвэгдсэний зэрэгцээ экологийн хэмжээлшгүй хямралыг араасаа дагуулсан тийм орчинд (2001.12.27-нд батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”-ийн хэллэгээр) Монгол улсын оршин тогтнох аюулгүй байдалтай шууд холбоотой амин чухал асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй болоод байна.

Өнөө үед аливаа улс үндэстний гео-потенциал, өөрөөр хэлбэл түүний “газрын хэвлийн баялаг” нь, ийм баялгийг агуулж буй тухайн орныхоо гадаад бодлогод тодорхой хэмжээний “эрх мэдэл” олгодог болжээ. Гэвч энэхүү баялгаа олборлож, үгүй ядахдаа анхан шатны боловсруулалт хийхэд шаардагдах санхүү, техник, технологийн бололцоо байхгүй бол тэрхүү “эрх мэдэл” нь харьцангуй байх юм. Тэгэхээр түншүүд, Монголын хувьд хожим нь лиценз зөвшөөрлөө цааш нь гуравдагч этгээдэд дамжуулан өгөхгүй гэх баталгаа гаргаж чадах тийм түншүүд хэрэгтэй. Тэр бүү хэл үүнийг одоогийн байдлаар Монгол улсын үндэсний аюулгүй байдлын жинхэнэ гол цөм асуудал гэж би нэрлэмээр

байна. Иймийн учир гуравдагч этгээдийн тухайд түншлэх түншийн гадаад бодлогын үзэл баримтлалаа сайтар нягтлан үзэх нь энэ цаг үеийн шаардлага мөн юм.

Үүнд олон улсын байдлын талаарх мэдлэг, анализ хийх чадвар нэн чухал бөгөөд энэ нь юуны өмнө МУИС-ийн Олон Улсын Харилцааны Сургууль, ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэн, Стратеги Судлалын Хүрээлэн зэрэг энэ чиглэлийн байгууллагуудын өмнө асар өндөр шаардлага тавигдаж байгаа хэрэг билээ. Гэхдээ Монголын гадаад бодлого дипломатууд нь жишээлбэл Москвагийн Олон Улсын Харилцааны Дээд Сургууль төгсөгчид байсан үедээ л хамгийн их амжилт олж байсныг нөхцөл байдал эрхгүй санагдуулж байна. Өнөөдөр Монгол Улсын Их Сургууль ч гэсэн энэ талаар онцгой үүрэг гүйцэтгэж байна. Өнөөгийн олон улсын харилцааны нарийн түвэгтэй ертөнцөд мэргэжилдээ сайтар гаршсан дипломатуудыг улс төрд гавьяа байгуулсан хүмүүсээр орлуулах боломж бараг байхгүй.

Дотоодын ардчилал тогтвортой байвал гадаад бодлогын ноён нуруу бэхжиж, тэр бүү хэл ингэсэн цагт л түүний үйл ажиллагаа баталгаажиж байдгийг Ц. Гомбосүрэн гуай тэртээ 1991 онд анхааруулсан байдаг юм. Өнөөгийнх шиг улс төрийн өнгө төрх сонгуулийн өмнө бужигнан алдагдаж, эрх зүйт төрд харш өдөр тутмын зарим үйл ажиллагаа үргэлжилсээр байваас энэ тал дээр маш сөрөг нөлөөтэй гэдэг нь илэрхий. Дотоодын тогтвортой байдлыг магадгүй шинэ загвараар дахин хангах, чингэхдээ монгол ухааныг гадаадын ноу-хаутай зөв хослуулах цаг нь нэгэнт болжээ. Энэ утгаараа Монголын соёл, уламжлал, үндэсний өөрөөрөө бахархах ухамсрыг сэргээн бататгах явдал Монгол улсын геополитикийн байрлал талаас нь аваад үзсэн ч надад туйлын чухал санагдаж байна.

Хууль гаргачихаад, дараа нь түүнийгээ парламентаа ч олигтой оролцуулалгүйгээр засварлах зэргээр хамтран ажиллаж болох түншүүдээ үргээчихгүй шиг байх нь мөн л дотоодын тогтвортой байдалд хамаатай.

Гэвч би өөдрөг үзэлтэй хүн. Аугаа их түүхтэй Монголын жижигхэн ч гэсэн ард түмэн сүүлийн арван долоон жилд цөөнгүй хямралыг амжилттай даван туулж чадсан юм, одоогийн энэ хямралаас ч мөн гарч чадна. Монголчууд юмыг амархан сурах, хөрвөх чадвартай байдаг нь магадгүй өмнөх үеийн нүүдэлчин амьдралаас нь үлдсэн хамгийн чухал өв биз ээ.